

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ИТГЭМЖЛЭЛИЙНТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэл, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн хууль тогтоомж

2.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

##### 3 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн зорилго, зарчим

3.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн зорилго нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүх төрлийн нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний харилцан орлолт, сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангахад оршино.

3.2. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэл, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.2.1. Хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдлыг хангасан байх;

3.2.2.бие даасан, хараат бус байх;

3.2.3.үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн байх;

3.2.4.худалдаанд үндэслэлгүйгээр техникийн саад тогтор учруулахгүй, ялгаварлахгүй байх;

3.2.5.сонирхогч талуудын оролцох эрхийг хангасан байх.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“стандартчилал” гэж бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нийтэй, нэгдмэл аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

4.1.2.“стандарт” гэж тодорхой хүрээнд зохимжтой хэм хэмжээ бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа буюу тэдгээрийн үр дүнд хамаарах ерөнхий зарчим, үзүүлэлтүүдийг нийтээр дахин давтан хэрэглүүлэхээр зөвшилцлийн үндсэн дээр боловсруулж, баталсан баримт бичгийг;

4.1.3.“салбарын стандарт буюу зохицуулалт” гэж /цаашид зохицуулалт гэх/ хуулиар тогтоосон эрхлэх асуудлын хүрээнд мөрдөхөөр төрийн захиргааны байгууллагаас баталсан баримт бичгийг;

4.1.4.“техникийн зохицуулалт” гэж стандарттаас эшлэл хэрэглэн бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлага, эсхүл боловсруулах, үйлдвэрлэх аргыг заавал мөрдөхөөр захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичгийг;

4.1.5.“бүтээгдэхүүн” гэж үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний үйл явцын үр дүн;

4.1.6.“үйлдвэрлэгч” гэж өөрийн нэр, эсхүл барааны тэмдэг доор бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийг;

4.1.7.“тохирлын үнэлгээний итгэмжлэл” гэж тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхийг нь эрх бүхий байгууллагаас тогтоож, албан ёсоор хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг;

4.1.8.“тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн, тогтолцоо, ажилтан, байгууллага нь стандарт, зохицуулалт, техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.9.“тохирлын үнэлгээний байгууллага” гэж энэ хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг;

4.1.10.“баталгаажуулалт” гэж бүтээгдэхүүн, үйл явц, тогтолцоо, ажилтан нь тогтоосон шаардлагад нийцэж буйг хөндлөгийн этгээд бичгээр нотлох ажиллагааг;

4.1.11.“нийлүүлэгчийн мэдэгдэл” гэж үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бүтээгдэхүүнээ тогтоосон шаардлагад нийцэж буй талаар бичгээр гаргасан нотолгоог;

4.1.12. “тохирлын тэмдэг” гэж бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ нь үндэсний стандартын тогтоосон шаардлагыг хангаж байгааг тодорхойлж, хөндлөнгийн тохирлын үнэлгээний байгууллагаас олгох тэмдэглэгээг;

4.1.13. “чанар аюулгүйн тэмдэг” гэж бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ нь техникийн зохицуулалтын тогтоосон шаардлагыг бүрэн хангаж байгааг тодорхойлж, хөндлөнгийн тохирлын үнэлгээний байгууллагаас олгох тэмдэглэгээг;

4.1.14.“тохирлын баталгаа” гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад тохирч байгааг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага тодорхойлж олгосон баримт бичийг;

4.1.15.“сорилт” гэж бүтээгдэхүүний тоо, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг холбогдох журмын дагуу тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.16.“шалгалт” гэж бүтээгдэхүүн, үйл явц, угсралт, суурилуулалт нь тэдгээрийн зохион бүтээлт, үйлдвэрлэгчээс тогтоосон шаардлага болон стандартад тохирч байгаа эсэхийг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.17.“зах зээлийн хяналт” гэж зах зээлд нийлүүлэгдсэн бүтээгдэхүүн нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэгдсэн хяналтын үйл ажиллагааг;

4.1.18.“лавлагаа гаргах” гэж бүтээгдэхүүний стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний журмын талаар хүсэлт гаргагчид албан ёсоор хариу өгөх ажиллагааг;

4.1.19.“мэдэгдэл гаргах” гэж олон улсын худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас техникийн зохицуулалтын төсөл, энэ хуулийн 18.3, 18.4-т заасан баримт бичгийн талаар Монгол Улсын нэрийн өмнөөс Дэлхийн худалдааны байгууллагад албан ёсоор нотлох үйл ажиллагааг;

4.1.20.“техникийн саад тогтор” гэж стандартын баримт бичиг, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд улс орны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаас бусад шалтгаанаар үндэслэлгүйгээр тогтоосон шаардлагыг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт

#### 5 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын тогтолцоо

5.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын тогтолцоо нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

5.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ стандартчилал, техникийн зохицуулалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

## **6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1.Төрийн захиргааны төв байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.эрхэлсэн салбар, чиглэлийнхээ стандарт, зохицуулалт, техникийн зохицуулалтын бодлогыг тодорхойлох;

6.1.2.эрхэлсэн салбар, чиглэлийн техникийн зохицуулалт боловсруулах, хууль тогтоомжийн хүрээнд салбарын стандарт буюу зохицуулалтыг батлах, мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

6.1.3.энэ хуулийн 4.1.4-т заасан баримт бичгийг боловсруулахдаа стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг авах;

6.1.4.салбарын тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг энэ хуулийн 7.1-т заасан байгууллагын саналыг үндэслэн томилох;

6.1.5.энэ хуулийн 6.1.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд орон тооны бус салбар, хороог байгуулах;

6.1.6. энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт тусгах.

6.2.Энэ хуулийн 4.1.19-т заасан үйл ажиллагааны журмыг худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.3.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 6.1-т заасан үйл ажиллагаа, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан төрийн захиргааны байгууллагын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ.

## **7 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

7.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрөөс стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.2.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг техникийн, байгалийн ухааны мэргэжилтэй, төрийн албанад 10-аас доошгүй жил, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан

төрийн албан хаагчаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж Засгийн газар томилно.

7.3.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.3.1.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний асуудлаар шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, дүрэм, журам, заавар боловсруулах, батлах;

7.3.2.үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулууны чанарын улсын хяналт тавих;

7.3.3.стандартыг батлах, бүртгэх, түүний албан ёсны эх хэвлэлийг бэлтгэх, хадгалах, олон нийтэд мэдээлэх, түгээх;

7.3.4.олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бус нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;

7.3.5.стандартчиллын техникийн хороодын үйл ажиллагааг зохицуулах;

7.3.6.стандартчилал, техникийн зохицуулалтын чиглэлээр төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

7.3.7.энэ хуулийн 13.5-д заасан байгууллагын стандартыг бүртгэх;

7.3.8.үндэсний чанарын шагналыг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

7.3.9.энэ хуулийн 7.3.6-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх:

7.3.10.олон улсын байгууллагыг стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний болон холбогдох бусад лавлагаа, мэдээллээр хангах;

7.3.11.олон улсын стандартчиллын төрөлжсөн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигийн дагуу үндэсний хэмжээнд зохион байгуулах.

## 8 дугаар зүйл. Мэдээлэл

8.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага нь мэдээлэл, лавлагааны төв ажиллуулна.

8.2.Мэдээлэл, лавлагааны төв нь бүтээгдэхүүнд хамаарах Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бус нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, техникийн зохицуулалт, удирдамж, зөвлөмж, аргачлал, заавар, тохирлын үнэлгээний журам болон холбогдох норматив-техникийн бусад баримт бичгийн албан ёсны эх, эсхүл хуулбар хувиас бүрдсэн үндэсний мэдээллийн сантай байна.

8.3.Мэдээлэл, лавлагааны төв нь төрийн мэдээллийн нөөц бөгөөд энэ хуулийн 13.2-т заасан баримт бичгийг төвлөрүүлэн бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, хадгалах, хамгаалах, мэдээлэх, хэвлэх, борлуулах үйлчилгээ эрхэлнэ.

**8.4.Мэдээлэл, лавлагааны төв нь үнэн зөв, бодит мэдээллээр нийтэд үйлчилнэ.**

**9 дүгээр зүйл. Орон нутгийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын бүрэн эрх**

**9.1.Орон нутгийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллага нь дараах бүрэн эрхтэй:**

**9.1.1.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад стандарт боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх;**

**9.1.2.стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн салбар санг ажиллуулах;**

**9.1.3.тохирлын үнэлгээг энэ хуульд заасны дагуу явуулах;**

**9.1.4.нутаг дэвсгэртээ энэ хуулийн 7.3.6-д заасан үйл ажиллагааг эрхлэх.**

**9.2.Орон нутгийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын даргыг байгалийн, техникийн ухааны мэргэжилтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 18.1-д заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцэж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилно.**

**10 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

**10.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах эрхтэй:**

**10.1.1.бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр дэвшилтэт стандарт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын үнэлгээнд хамрагдах;**

**10.1.2.стандарт боловсруулах үйл ажиллагаанд оролцох;**

**10.1.3.стандарт, стандартчиллын хөтөлбөрийн төсөлд санал өгөх.**

**10.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах үүрэгтэй:**

**10.2.1.стандарт, техникийн зохицуулалтад тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;**

**10.2.2.энэ хуульд заасан стандартыг боловсруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулах, түүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх;**

**10.2.3.стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний асуудлаар холбогдох дүрэм, журам, баримт бичиг боловсруулах чадварыг ажилтанд сургалтаар олгох;**

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Стандартчилал

#### **11 дугаарзүйл. Стандартчиллын зорилго**

11.1.Стандартчиллын зорилго нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, улсын аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний нийцтэй, харилцан орлуулалт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангахад оршино.

#### **12 дугаар зүйл. Стандартчиллын баримт бичиг**

12.1.Стандартчиллын баримт бичигт дараахь баримт бичиг хамаарна:

12.1.1.Монгол Улсын /цаашид “үндэсний” гэх/ стандарт;

12.1.2.стандартчиллын арга зүйн удирдамж, зөвлөмж;

12.1.3. байгууллагын стандарт;

12.1.4. олон улс, бус нутгийн стандартчиллын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмж.

#### **13 дугаар зүйл. Стандарт**

13.1.Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бус нутгийн стандартын шаардлагад нийцсэн байна.

13.2.Үндэсний стандарт нь зөвшилцлийн үндсэн дээр боловсруулж, баталсан баримт бичиг тул зохиогчийн эрхэд хамаarahгүй.

13.3.Стандартчиллын техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцэлд хүрсэн стандартын төслийг улсын хэмжээнд хэрэглэхээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрч, үндэсний стандарттаар батална.

13.4.Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

13.5.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хууль болон стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан нийтлэг стандарт, арга зүйн дагуу боловсруулсан байгууллагын стандартыг улсын бүртгэлд бүртгүүлсэний үндсэн дээр дагаж мөрдөнө.

13.6.Энэ хуулийн 13.5-д заасан байгууллагын стандарттаар тогтоосон үзүүлэлт, шаардлага нь үндэсний стандарт, техникийн зохицуулалттай нийцсэн байна.

#### **14 дүгээр зүйл. Стандартчиллын техникийн хороо**

14.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үндэсний болон олон улс, бус нутгийн стандартын төслийг боловсруулах, хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий салбарын орон тооны бус стандартчиллын техникийн хороо /цаашид “Техникийн хороо” гэх/-г төр, иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон бусад байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулж ажиллуулна.

14.2.Техникийн хороо дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.2.1.стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагын санал авах, сонирхогч талуудтай зөвшилцэх;

14.2.2.стандартын төсөл боловсруулахтай холбогдуулан мөрдөгдэж байгаа стандартад үзлэг, үнэлгээ хийх, шаардлагатай бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

14.2.3.үндэсний болон олон улс, бус нутгийн стандартын төсөлд санал өгөх, дүгнэлт гаргах;

14.2.4.шаардлагатай тохиолдолд техникийн дэд хороо байгуулж ажиллуулах.

14.3.Техникийн хороо түүний гишүүд нь иргэн, байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөхгүй бөгөөд тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй байна.

## **15 дугаар зүйл. Стандарт хэрэглэх, мөрдөх**

15.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэсний стандартыг сонгон хэрэглэнэ.

15.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй олон улс, бус нутаг, гадаад улсын дэвшилттэй стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон түүний салбар орон нутгийн байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэнэ.

15.3.Аж ахуйн нэгж, байгууллагын шийдвэр, гэрээнд стандартыг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг эш татаж болох бөгөөд энэ нь тухайн баримт бичгийн нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөх эрх зүйн баримт бичиг болно.

15.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үндэсний стандартыг хувилан олшруулах, энэ хууль болон эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй өөр стандарт хэрэглэхийг хориглоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **Техникийн зохицуулалт**

### **16 дугаар зүйл. Техникийн зохицуулалт**

16.1. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үндэсний болон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөнө.

## **17 дугаар зүйл. Техникийн зохицуулалтыг боловсруулах, батлах**

17.1. Тодорхой салбарт мөрдөх техникийн зохицуулалтыг тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

17.2. Техникийн зохицуулалтын төслийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн хянуулж, санал заавал авна.

17.3. Техникийн зохицуулалт боловсруулах аргачлалыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

17.4. Хуулиар эрх олгогдсон тохиолдолд техникийн зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж болно.

17.5. Энэ хуулийн 17.2-т заасан төслийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсаас олон улсын худалдаанд хэрэглэхээр санал болгосон техникийн зохицуулалтыг батлахаас гурваас доошгүй сарын өмнө Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад энэ тухай мэдээлнэ.

## **18 дугаар зүйл. Стандарт, техникийн зохицуулалтын мэдээллийн сан**

18.1. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санг хөтөлнө.

18.2. Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн сан нь үндэсний стандарт, зохицуулалт, техникийн зохицуулалт, олон улс, бүс нутаг, гадаад орны стандарт, тохирлын үнэлгээний асуудлаарх гэрээ, хэлэлцээр, байгууллагын стандарт, журам болон холбогдох бусад норматив баримт бичгээс бүрдэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ Тохирлын үнэлгээ, итгэмжлэл**

### **19 дүгээр зүйл. Тохирлын үнэлгээ**

19.1. Тохирлын үнэлгээг бүтээгдэхүүн, үйл явц, удирдлагын тогтолцоо, үйлчилгээнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зөв сонголт хийхэд туслах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хэрэглэнэ.

19.2. Нийтийн ашиг сонирхол, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд заавал хамруулна.

19.3. Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчийн хүсэлтээр тохирлын үнэлгээнд хамруулж болно.

19.4. Энэ хуулийн 19.2-т заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

19.5. Тохирлын баталгааг хэрэглэх, харилцан хүлээн зөвшөөрөх талаар Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрнө.

19.6. Тохирлын баталгаа нь баталгаажуулалт, нийлүүлэгчийн мэдэгдэл гэсэн хэлбэртэй байна.

19.7. Энэ хуулийн 19.8-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан үйлдвэрлэгч бүтээгдэхүүндээ нийлүүлэгчийн мэдэгдлийг гаргаж болно.

19.8. Нийлүүлэгчийн мэдэгдэл гаргах журмыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

19.9. Энэ хуулийн 19.7-д заасан нийлүүлэгчийн мэдэгдэл тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

19.10. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 19.4-д заасны дагуу зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр чанар аюулгүйн тэмдэгтэй бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.

19.11. Чанар аюулгүй байдал, тохирлын тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журмыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

## **20 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний байгууллага**

20.1. Тохирлын үнэлгээний байгууллага нь холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

20.2. Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэ хуулийн 23.1-т заасан байгууллагаар итгэмжлэгдсэн байна.

20.3. Гадаад орны итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэл авсан тохирлын үнэлгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх бол энэ хуулийн 23.1-д заасан байгууллагад бүртгүүлсэн байна.

20.4. Тохирлын үнэлгээний байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд байна.

20.5. Тохирлын үнэлгээний байгууллага дараахь эрхтэй:

20.5.1.өөрийн чадавхийн хүрээнд стандарт, техникийн зохицуулалт, холбогдох норматив баримт бичигт үндэслэн тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх;

20.5.2.тохирлын үнэлгээний үр дүнг үндэслэн тайлан, гэрчилгээ, тохирлын тэмдэг, үнэмлэх олгох, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

#### 20.6.Тохирлын үнэлгээний байгууллага дараах үүрэгтэй:

20.6.1.тохирлын үнэлгээний ажилд эрх бүхий холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах;

20.6.2.тохирлын үнэлгээний дүн, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.

20.7. энэ хуулийн 20.2, 20.3-т заасан заалтыг зөрчин тохирлын үнэлгээний үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ Итгэмжлэл**

#### **21 дүгээр зүйл. Итгэмжлэлийн зорилго**

21.1.Итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тогторыг арилгах, худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэл үнэмшлийг хангах, тохирлын үнэлгээний дүнг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

#### **22 дугаар зүйл. Итгэмжлэлийн тогтолцоо, удирдлага зохион байгуулалт**

22.1.Итгэмжлэлийн тогтолцоо нь итгэмжлэлийн Удирдах зөвлөл(цаашид “Зөвлөл” гэх), итгэмжлэлийн байгууллага, техникийн хороод, маргаан шийдвэрлэх хороо, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагаас бүрдэнэ.

22.2.Зөвлөл нь төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх итгэмжлэлийн тогтолцооны стратеги, бодлого, зохицуулалтыг тодорхойлох, түүнд хяналт тавих үүрэг бүхий төрийн ба төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн, орон тооны бус 15 гишүүнтэй байна.

22.3.Зөвлөлийн ажиллах дүрмийг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.4.Зөвлөлийн гишүүдийг доор дурдсан байгууллагаас гурван жилийн хугацаатай томилно.

22.4.1. төрийн захиргааны төв байгууллага;

22.4.2. стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцантөрийн захиргааны байгууллага;

22.4.3. тохирлын үнэлгээний байгууллага;

22.4.4.төрийн бус байгууллага;

22.4.5. шинжлэх ухаан боловсролын байгууллага;

22.5.Зөвлөлийн гишүүн нь техникийн болон байгалийн ухааны мэргэжилтэй, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна.

22.6.Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэр дэвшиүүлж, хамгийн олон санал авсан гишүүнийг даргаар сонгоно.

### **23 дугаар зүйл. Итгэмжлэлийн байгууллага**

23.1. Итгэмжлэлийн чиг үүргийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Итгэмжлэлийн газар хэрэгжүүлнэ.

23.2.Итгэмжлэлийн байгууллага нь тохирлын үнэлгээний байгууллагын чадавхийг олон улсын стандарт, шалгуурын дагуу үнэлж, итгэмжлэлийн гэрчилгээ олгоно.

23.3. Итгэмжлэлийн байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.3.1.итгэмжлэлийн хороог байгуулж, тэдгээрийн дүрмийг батлах, үйл ажиллагааг зохицуулах;

23.3.2.тохирлын үнэлгээний байгууллагад итгэмжлэл олгох, чадавхийг нотлох, холбогдох шийдвэр гаргах, мэдээлэх

23.3.3.итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын улсын нэгдсэн бүртгэлийг бий болгох, хөтлөх;

23.3.4.итгэмжлэлийн үнэлгээний мэргэжилтэн, шинжээчид тавих шаардлагыг тогтоох, нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, эрх олгох, нөөцөд бүртгэх, тэдгээрийг гэрээний үндсэн дээр ажиллуулах, гүйцэтгэлийг шалгах, эрхийг цуцлах;

23.3.5.эрхэлсэн асуудлаар сургалт явуулах буюу мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

23.3.6. Олон улс, гадаад орны итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагад Монгол улсыг төлөөлөх, хөгжүүлэх.

23.3.7. Олон улс, бус нутаг болон хоёр талын хүрээнд итгэмжлэлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг дэмжих;

23.4.Тохирлын үнэлгээний байгууллагаас итгэмжлэлийн талаар гаргасан гомдол, маргааныг маргаан шийдвэрлэх комисс шийдвэрлэнэ.

23.5.Энэ хуулийн 22.2-т заасан Зөвлөл маргаан шийдвэрлэх комиссыг тухай бүр байгуулж, ажиллах журмыг нь батална.

22.6.Итгэмжлэлийн шинжээч дараах эрх, үүрэгтэй:

23.6.1.итгэмжлэлийн байгууллагын шийдвэрээр тохирлын үнэлгээний байгууллага нь тогтоосон шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг баримт бичгийн түвшинд, газар дээр нь шалган үнэлэх, тайлагнах;

23.6.2.итгэмжлэлийн үнэлгээний талаар эцсийн дүгнэлт гарахаас өмнө тодорхой асуудлаар хувийн үнэлгээ, байр сууриа илэрхийлэхгүй байх;

23.6.3.итгэмжлүүлэхээр хүсэлт гаргагч байгууллагатай хөдөлмерийн болон бусад гэрээгээр хамтран ажилладаг, сонирхлын зөрчил үүсч болзошгүй бол итгэмжлэлд оролцоо татгалзах.

23.6.4.итгэмжлэлийн байгууллагын шийдвэрт нөлөөлөх, нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаанаас ангид байх;

### **ДОЛДУГААР БҮЛЭГ** **Техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдох** **үйл ажиллагаанд тавих төрийн хяналт**

**24 дүгээр зүйл. Техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдох үйл ажиллагаанд тавих төрийн хяналт**

24.1.Зохицуулалт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдох үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

24.2.Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 11.9-д зааснаас гадна дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

24.2.1.стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай хууль тогтоомж, зохицуулалт, техникийн зохицуулалтын биелэлтэд хяналт тавих;

24.2.2.энэ хуулийн 19.2-т заасан бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулсан эсэхэд хяналт тавих.

24.3.энэ хуулийн 24.2-т заасан хяналтыг хэрэгжүүлэх мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй чиглэлээр сургалтад хамрагдаж, энэ хуулийн 7.1-т заасан байгууллагаас гэрчилгээ авсан байна.

24.4.Мэргэжлийн хяналтын байгууллага нь энэ хуулийн 24.1, 24.2-т заасан үйл ажиллагааны дүн шинжилгээг энэ хуулийн 7.1-д заасан Зөвлөлд жил бүр тайлагнана.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ** **Бусад зүйл**

**25 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт,**  
**итгэмжлэлийн санхүүжилт**

25.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон түүний харьяа орон нутгийн байгууллага, итгэмжлэлийн байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй

холбогдсон зардал, Үндэсний зөвлөл, итгэмжлэлийн удирдах зөвлөл, стандартчиллын болон итгэмжлэлийн техникийн хороо, итгэмжлэлийн маргаан шийдвэрлэх комиссын үйл ажиллагаатай холбогдсон зардал, олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төсвөөс, энэ хуулийн 6.1.5, 7.3.1-д заасан үйл ажиллагааны зардлыг Шинжлэх ухаан, технологийн сангаас тус тус санхүүжүүлнэ.

25.2. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь холбогдох журмын дагуу Стандартчилал, техникийн зохицуулалтын чиглэлээр техникийн шинэчлэл, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зардлыг үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын сангаас, энэ хуулийн 7.3.11 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны зардлыг гишүүнчлэлийн татвар, олон улсын байгууллагын гэрээнд заасан үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэх эрхийг хэрэгжүүлнэ.

25.3. Итгэмжлэлийн үйл ажиллагааны санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 25.3.1. улсын төсөв;
- 25.3.2. итгэмжлэлийн ажил үйлчилгээний хураамж;
- 25.3.3. итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хураамж;
- 25.3.4. итгэмжлэлийн үйл ажиллагаатай сонирхлын зөрчилгүй аж ахуйн нэгж, байгууллагын тусlamж, хандив;
- 25.3.5. Монгол улсын чанарын дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэг;

25.4. Энэ хуульд заасан ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

## **26 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

26.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

27.1. Энэ хуулийг 2017 оны ...дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ